



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/19

Мандалговь

“Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд
10 бункер” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд 10 бункер” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)

Э.Уянга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Б.Төвшинжаргал (Онцгой байдлын газрын нягтлан бодогч)


Нарийн бичгийн дарга:

Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Энхмэнд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210079